

## Хүртээмжтэй даатгалын үйл ажиллагаа:

Хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-д **“хүртээмжтэй даатгал”** гэж иргэн бүрийг хамруулах зорилго бүхий, даатгалын гэрээний үг хэллэг нөхцөл нь энгийн ойлгомжтой, даатгалын хураамжийн хэмжээ болон нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөлийн тоо бага байх сайн дурын даатгалын бүтээгдэхүүнийг хэлнэ гэж тодорхойлсон.

## Хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнд тавигдах шаардлага:

Хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын дагуу Хороо хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэх ба бүртгэхэд дараах шаардлагыг тавьж ажиллаж байна:

1. Даатгалын хураамж болон эрсдэлийн хэмжээ нь бага, дунд орлоготой иргэдэд зориулагдсан байх;
2. Даатгалын гэрээнд тусгасан нөхөн төлбөрийн хасалтын тоо 5-аас ихгүй байх;
3. Даатгалын гэрээ нь хоёрдмол утга санаагүй, бусдад шууд ойлгохоор үг, хэллэгтэй байх;
4. Даатгалын нөхөн төлбөрийг ажлын 10 хоногт олгодог байх.

Хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнийг Хороо бүртгэхдээ код өгөх бөгөөд уг код нь “ХД” үсгийн ард дугаар, оныг илэрхийлсэн цифрийг тусгана. /Тухайлбал: ХД0012016 гэснийг 2016 оны 001 дугаартай хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүн гэж ойлгох/

## Хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүн:

2018 оны 1 дүгээр улирлын байдлаар Хороонд бүртгүүлсэн даатгалын 4 компанийн хүртээмжтэй даатгалын 7 бүтээгдэхүүн байна:

№	Даатгалын компани	№	Хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүн	Бүтээгдэхүүний код
1	"Монре даатгал"ХХК	1	Гэр хашаа байшингийн даатгал	ХД0012015
2	“Улаанбаатар хотын даатгал” ХХК	2	Гэр хашаа байшингийн даатгал	ХД0022017
		3	Өрхийн гэнэтийн ослын даатгал	ХД0032017
		4	Хүүхдийн гэнэтийн ослын даатгал	ХД0022015
3	"Хаан даатгал" ХХК	5	"Орон сууцны иж бүрэн даатгал"	ХД0012017
4	“Монгол даатгал” ХХК	6	Иргэдийн гэнэтийн ослын хүртээмжтэй даатгал	ХД0012018
		7	Гэр хашаа байшингийн хүртээмжтэй даатгал	ХД0022018